

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН СҮЛД ЧУУЛГЫН 2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2020 оны 12 дугаар сарын 23.

Улаанбаатар хот

Нэг. Удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн талаар

Тус чуулга нь хуулиар олгосон үндсэн чиг үүргээ биелүүлэхийн зэрэгцээ төрийн хууль тогтоомж, дээд шатны байгууллагын тушаал, шийдвэр, цаг үеийн холбоотой зөвлөмж, ажлын чиглэлийг удирдлага болгон, эхний хагас жилд 42 ажил, сүүлийн хагас жилд 46 арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЦЕГ-ын ЗУГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллав.

Жилийн эцсийн байдлаар чуулгад нийт 897 бичиг ирж, 460 бичиг холбогдох харьяа нэгжид цахимаар болон шуудангаар хүргэгдсэн байна.

Чуулгын даргын нэр дээр ажилд орох, суралцахыг хүссэн 20, захиргааны чөлөө хүссэн 43, тэтгэвэр тэтгэмж, орон сууц хүссэн 4, бусад 25, нийт 102 өргөдөл, гомдол ирж, чуулгын даргаас нийт 14 удаа үүрэг өгөгдсөнөөс нийт бие бүрэлдэхүүнд хамаарах 61 үүргийг бичгээр болон амаар өгч, даргын зөвлөлийн хурал нийт 17 удаа хийгдэж, А буюу үйл ажиллагаатай холбоотой тушаал 25, Б буюу хүний нөөцтэй холбоотой тушаал 74 гарч, хэрэгжилтийг хангаж ирэв.

Хүний нөөцийн бодлогын хүрээнд чуулгын орон тоог нэмэгдүүлэх, нэгжийн удирдлага зохион байгуулалтын бүтцийг бэхжүүлэх, бие бүрэлдэхүүний ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч цагдаа, дотоодын цэргийн 32 анги, байгууллагад орон тоо хүссэн алба бичгийг хүргүүлэхэд 29 байгууллага боломжгүй, 5 байгууллага шийдвэрлэн 5 орон тоо, цалингийн сангийн хамт шилжүүлж ЦЕГ-ын даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/53 дугаар тушаалаар Сүлд чуулгын албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэн баталж 73 хүний орон тооны бүтэцтэй зохион байгуулагдан ажиллаж байна.

ЦЕГ-ын даргын 2020 оны Б/701 дүгээр тушаалаар Сүлд чуулгын дарга, цагдаагийн хурандаа Лэгдэнсүрэнгийн Гаваасүрэнг ажлаас чөлөөлж ЦЕГ-ын даргын 2020 оны Б/710 дугаар тушаалаар Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын даргаар ажиллаж байсан цагдаагийн хурандаа Г.Эрдэнэбаатарыг чуулгын даргаар томиллоо.

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар 1, “Цагдаагийн гавьяа” тэмдэгээр 2, ЦЕГ-ын “Хүндэт жуух”-аар 2, Залуучуудын холбооны “Хөдөлмөрийн алдар” медалиар 5 алба хаагч шагнагдаж, цагдаагийн дэд хурандаа цол 1, цагдаагийн дэслэгч цол 1, цагдаагийн ахлагч цол 4 нийт 6 алба хаагчид олгогдсон.

ЦЕГ-ын даргын тушаалаар ажлаас 1 алба хаагч, чуулгын даргын тушаалаар 4 алба хаагч, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгож 2 алба хаагч албанаас чөлөөлөгдөж, 4 алба хаагч шилжиж, ЦЕГ-ын ХНХ-ийн зөвшөөрлөөр 9 алба хаагч, чуулгын даргын тушаалаар 4 алба хаагч, ажилтныг томилж, 3 алба хаагчийн хүүхэд асрах чөлөөг цуцалж, ажилд томилсон байна.

Энэ онд 2 алба хаагч сахилгын шийтгэл хүлээж, ажлын үр дүнгээр 4 алба хаагчийн цалинг хасч, 81 алба хаагчийн ажлын үр дүнгээр цалинг нэмж урамшуулсан.

Чуулгын даргын 2020 оны А/19 дүгээр тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх орон тооны бус дэд зөвлөлийг байгуулж, төлөвлөгөө, хөтөлбөрийг батлуулж тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2021 онд ЦБ-ын 100 жилийн ой тохиохтой холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/310 дугаартай тушаалаар “Ажлын хэсэг” шинэчлэн байгуулагдаж, Дотоодын цэргийн штабын дарга, хурандаа С.Ганбатаар ахлуулсан “Урлаг, соёлын арга хэмжээний дэд ажлын хэсэг”-ийн нарийн бичгийн даргаар чуулгын дарга томилогдон бэлтгэл ажлын төлөвлөгөөг

шинэчлэн батлуулж, тус чуулгын шууд хариуцсан ажиллах 10 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх 10 дэд хэсгийг байгуулан ажиллаж байна.

Хоёр. Сахилга хариуцлагыг төлөвшүүлэх, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлын арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар

2020 онд 2 алба хаагч сахилга, ёс зүйн дутагдал гаргаж, 1 алба хаагч “сануулах”, “албан тушаалын цалинг 20% бууруулах” сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд чуулгын сахилгын мэдээг сар бүр гарган хүргүүлж ирэв.

Алба хаагчдын сахилга "Сахилгын зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, зөвлөгөөнд Цагдаагийн ерөнхий газрын Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа Х.Мөнх-Эрдэнэ цагдаагийн байгууллагын хэмжээнд Алба хаагчийн сахилга дэг журмыг сайжруулах талаар авч хэрэгжүүлж байгаа бодлого чиглэл, 2020 оны эхний 9 сарын цагдаагийн байгууллагын сахилгын зөрчлийн тоон мэдээлэл, харьцуулсан үзүүлэлтийн талаар мэдээлэл хийж, чуулгын нийт 64 алба хаагч, ажилтан хамрагдсан.

Ёс зүйн зөрчил гаргасан 2 алба хаагчид “Итгэл найдварын хуудас” гардуулж, дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллах талаар нийт бүрэлдэхүүний дунд амлалт баталгаа гаргуулан, цаашид хэрхэн ажиллах талаар үүрэг ажлын чиглэлийг нийт бүрэлдэхүүнд өгсөн.

ЦЕГ-ын даргын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Б/247 дугаар тушаалаар цагдаагийн ахлах ахлагч Э.Батбаярт оногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас өмнө сахилгын шийтгэлгүйд тооцож чуулгын хөгжимчний ажлаас мөн оны 03 дугаар сарын 23-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж мөн чуулгад хөгжмийн багш, удирдаачаар томилж цагдаагийн ахмад цолыг сэргээн олгосон.

Тус чуулгад шинээр томилогдон ахлагчийн бүрэлдэхүүнд орсон 14 алба хаагч цагдаагийн тангараг өргөв.

Алба хаагчдын сахилга, ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой 6 удаагийн 10 цагийн сургалтад 382 алба хаагчийг хамруулсан.

Цагдаагийн байгууллагаас 2020 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд офицер алба хаагчдын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, офицеруудын манлайлал, хариуцлага, харилцааны соёл, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар 9 чиглэл гаргаж, төрийн нийт албан хаагчид эрхэмлэн дагаж мөрдөх “Төрийн алба хаагчийн эрхэмлэх есөн зүйл”-ийг бие бүрэлдэхүүнд нэг бүрчлэн ойлгуулан таниулж, мөрдүүлж ирлээ.

Цагдаагийн байгууллагаас 2020 онд дэвшүүлсэн удирдлагын манлайлал, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, харилцааны соёлыг дээшлүүлэх, үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлж, бүтээлч санал, санаачилгыг дэмжих зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд офицер алба хаагчдын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, офицеруудын манлайлал, хариуцлага, харилцааны соёл, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар 9 чиглэл гаргаж, 14 офицер алба хаагч хөрөнгө орлогын мэдүүлгийг meduuleg.iaас.mn цахим хаягаар бүртгүүлж, баталгаажуулан хүргүүлэв.

Сургалтын чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны А/07 дугаар тушаалаар баталсан “Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-ний дагуу ЦЕГ-ын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсээс ирүүлсэн 80 цагийн сургалт бүхий “Албаны сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөө”-нд 25 цагийн сургалтыг нэмж тусган чуулгын даргын 2020 оны А/05 дугаар тушаалаар 9 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй “Албаны сургалтын баг” байгуулж, хавсралтаар 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 12 арга хэмжээ бүхий төлөвлөгөө, 65 сэдвээр 105 цагийн хичээл бүхий хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллав.

ЦЕГ-ын даргын 2017 оны А/211, А/99 дүгээр тушаал ЦБҮАЖ-ын код 118, 239, 951, ЦЕГ-аас ирүүлсэн ажлын чиглэл, 2020 онд явуулах албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөгөөр мэдээлэл бэлтгэн алба хаагчдад ойлголт өгсөн бөгөөд 2020 онд 135

сэдвээр 222 цагийн сургалтыг давхардсан тоогоор 8005 алба хаагчийг хамруулан давхардсан тоогоор 21 зочин багш, мөн давхардсан тоогоор чуулгын 47 офицер явууллаа.

Хэлбэрийн хувьд танхимын сургалт 40, дадлага 24, зайн болон цахим сургалт 72 удаа явагдсан.

Мөн оны өмнөх үетэй харьцуулахад сургалтын тоо 64%-иар, хамрагдсан алба хаагчдын тоо 70%-иар өссөн үзүүлэлттэй байна.

2020 онд мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалтын хүрээнд 68 удаагийн 99 цагийн сургалтыг 4050 алба хаагчийг хамруулан хууль, эрх зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэв.

Алба хаагчийг хөгжүүлэх сургалтын хүрээнд 32 удаагийн 59 цагийн сургалтыг 1911 алба хаагчийг хамруулан зохион байгуулав.

Дадлагажуулах сургалтын хүрээнд 14 удаагийн 24 цагийн сургалтад 857 алба хаагчийг хамруулсан.

Сургалтын шинэлэг хэлбэрийг нэвтрүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна. Тухайлбал Гэр бүл анхаарлын төвд төрийн бус байгууллагын сэтгэл зүйчийг урьж сургалт явуулахын зэрэгцээ Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвд бодит орчинд дадлага сургуулилт хийж, ойлголт мэдлэгээ нэмэгдүүлсэн юм.

“Гамшгаас хамгаалах дадлагажуулах сургалт”-ыг Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвд зохион байгуулж, сургалтаар гамшгийн төрөл, хор уршиг, гамшгаас урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон бусдыг хамгаалах, утааны төрөл, утаажилттай орчноос зайлан гарах дадлага, гал түймэр, түүнийг үүсэгч хүчин зүйлс, гал унтраах багаж ашиглах дадлага, осол, гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх дадлага, газар хөдлөлтийг биеэр мэдрэх, учирч болзошгүй эрсдлийн үед авах аюулгүйн арга хэмжээний талаарх ойлголт өгөх дадлага, өндрөөс унах, өндрөөс аврах ажиллагаа, олс зангидалтын аргуудын талаарх ойлголт өгөх зэрэг агуулгын хүрээнд явагдаж, 3D кино театр, утаат орчны танхим, галын аюулаас сэргийлэх танхим, бага насны хүүхдийн аврах танхим, эмнэлгийн анхан шатны тусламжийн танхим, газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхим, өндрөөс аврах танхим зэрэг бодит байдлыг биеэр мэдрэх боломжтой орчинд явагдах учир алба хаагчдад гамшгаас сэргийлэх, хамгаалах дадлыг үр дүнтэй олгосон онцлог сургалт байсан юм.

Чуулгаас мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх, өөрийгөө хөгжүүлэх сургалт хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан алба хаагчдыг дэмжиж, суралцах нөхцөл бололцоогоор ханган ажилласан бөгөөд тайлант хугацаанд Дотоод Хэргийн Их сургуулийн бакалаврын 2020-2021 оны хичээлийн жилийн эчнээ сургалтад 2 алба хаагч, Их засаг хууль зүйн сургуулийн бакалаврын эчнээ сургалтад 4, Соёл урлагийн их сургуулийн бакалаврын эчнээ ангид 1, магистрантурт 2, Монгол Улсын Их сургуулийн докторын сургалтад 2 алба хаагч хамрагдаж байна.

Мөн тайлант хугацаанд Монгол Улсын Их сургуулийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимд “Хүрээ дууны донж маяг” сэдвээр тус чуулгын цагдаагийн музейн эрхлэгч /сургалт-эрдэм шинжилгээний ахлах ажилтан/, цагдаагийн ахмад С.Дуламсүрэн магистрын зэрэг хамгаалж, Дотоод хэргийн их сургуулийн бакалаврын эчнээ сургалтад дууны хэсгийн ахлагч, цагдаагийн дэслэгч Г.Дарханбаатар амжилттай хамрагдаж Аюулгүй байдлын бакалавр цагдаа-эрх зүйч мэргэжлээр төгсөж, Их засаг их сургуулийн Хууль зүйн сургуулийн бакалаврын эчнээ сургалтад бүжигчин, цагдаагийн ахлагч М.Энхзолбоо хамрагдаж, эрх зүйч мэргэжил эзэмшсэн.

ЦЕГ-ын даргын Б/349 дүгээр тушаалын дагуу “Мэргэжил олгох цахим сургалт”-д тус чуулгаас Дармаабазарын Бямбасүрэн, Сүхбатын Тэмүүлэн нар хамрагдаж, Д.Бямбасүрэн амжилттай төгсөж гэрчилгээг гардан авсан.

“Амар” сургалтын төвийн “Илтгэх ур чадварын сургалт”-д бүжигчин, цагдаагийн ахлагч М.Энхзолбоо хамрагдаж 05/397 дугаартай гэрчилгээг гардан авсан болно.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Б/854 дугаартай тушаалаар ДХИС-ийн Гадаад хэлний институтын орос хэлний анхан шатны дамжаанд тус чуулгын СГАСХариуцсан ахлах мэргэжилтэн суралцсан.

Сургалтын нэгдсэн төвөөс Монголын Хүний нөөцийн Институттэй хамтран зохион байгуулсан “Хамт олныг сэдэлжүүлэх удирдлага” багц сургалтын хүрээнд 4 сэдвээр явуулсан цахим хичээлд чуулгын 6 алба хаагч хамрагдав.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэн, хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын сургалтад чуулгын хүний нөөцийн мэргэжилтэн хамрагдав.

Чуулгын 16 офицер алба хаагчид Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан “Мэдүүлэг гаргагчдад зориулсан гарын авлага”-ыг тараан судлуулж, бие бүрэлдэхүүнд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3/254 дугаартай ажлын чиглэлийг танилцуулсан.

Цахим сургалтын нэгдсэн систем /Test server Moodle/ программыг албаны сургалтын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, ашиглах зорилгоор өмнө нэвтрэх эрх баталгаажсан 10 алба хаагч дээр нэмж нэвтрэх эрхгүй байсан 36 алба хаагчид МТХТ-д хандан PU код авч СНТ-д тус алба хаагч нарт шалгалтын цахим системд нэвтрэх эрх авах хүсэлтийг илгээж 46 алба хаагчийн эрхийг баталгаажуулсан болно.

Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл, түүнтэй тэмцэхэд анхаарах зарим асуудал сэдэвт багц сургалтын хүрээнд хүний эрхийн чиглэлийн 4 видео хичээлийг 57 алба хаагчид цахим хэлбэрээр судлуулж, цахим шалгалтын нэгдсэн системд нэвтрэх эрх бүхий PU кодтой 10 алба хаагч шалгалт өгч, 6 алба хаагч 90-100, 4 алба хаагч 80-89%-иар үнэлэгдсэн байна.

Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар зэрэг агуулгын хүрээнд 50 асуулт бүхий тестээр 48 алба хаагчаас шалгалт авч, дүнг /А-2, В-4, С-18, D16, F-8/ нэгтгэн гаргасан алдааг засч тайлбарлаж өгч алба хаагчдын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд зохион байгуулагдаж буй офицер бэлтгэх сургалтад хамрагдаж байгаа 130 алба хаагчид Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа сэдэвт 4 цагийн хичээлийг соён гэгээрүүлэх, албаны сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн орсон.

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цахим буюу зайны сургалтын хэлбэрт түлхүү шилжсэн бөгөөд цагдаа, дотоодын цэргийн байгууллагуудаас шинэлэг хэлбэрээр бэлтгэн ирүүлсэн 36 төрлийн сургалтын видео сургалтад ашиглаж, 172 ширхэг сургалтын материал олшруулж тараасан ба албаны сургалтад нийт 440.000 төгрөгийг зарцуулсан.

Соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр: Тус чуулгаас Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/08 дугаартай тушаалаар баталсан 2 бүлэг 25 ажил, арга хэмжээ бүхий “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2020 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангаж, энэ онд цахим болон бусад хэлбэрээр нийт 190 удаагийн ажил, арга хэмжээг давхардсан тоогоор 11850 алба хаагчийг хамруулан зохион байгууллаа.

Мэдээлэл сурталчилгааны 100, урлаг, спорт, соёл хүмүүжлийн чиглэлээр 90 ажил зохиож, энэ онд соён гэгээрүүлэх чиглэлийн ажил цахим хэлбэрээр голчлон явагдаж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 59%-иар, хамрагдсан алба хаагчдын тоо 50%-иар өссөн байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагч, тэдний гэр бүл, иргэд олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Сүлд чуулгыг бүрэлдэхүүний хувьд бэхжүүлэхэд онцгой анхаарал тавьж орон тоо зохицуулан гаргаж өгч дэмжлэг үзүүлсэн Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын нэр бүхий 10 даргад талархлын захидал хүргүүлж уг захидлын нэг хувийг тухайн дарга нарын хувийн хэрэгт баяжилт хийлгэхээр

чуулгын даргын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны 26/117 тоот албан бичгээр ЦЕГ-ын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлэв.

ЦДЦБ-ын алба хаагчдын авьяаслаг хүүхдүүдэд чиглэсэн “Өсвөрийн соён гэгээрүүлэгч цагдаа” хөтөлбөрийн хүрээнд 09-11 насны бүжгийн авьяастай хүүхдүүдийг сонгон шалгаруулж НЦУГ-аас 22 хүүхдийн нэрс ирснээс “Муурын байшин” бүрэн хэмжээний бүжгийн жүжгийн тавилтад 15 хүүхэд тусгайлсан хуваарийн дагуу бэлтгэл хийсэн. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан бэлтгэлийг түр зогсоосон байна.

Цагдаа, Дотоодын цэргийн алба хаагч, ажилчдад зориулсан ажлын байрны дасгал “Гиртэй дасгал”-ын зураг авалтыг Хүч спорт хороотой хамтран хийж, цагдаагийн байгууллагын нэгдсэн системийн сургалтын материал хэсэгт байршуулав.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж КОВИД-19 цар тахалтай холбогдуулан урт хугацаанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдаас онцлон 6 байршилд 20 гаруй хүнээс ярилцлага, Судан Улсын Дарпур муж, Сэлэнгэ аймгийн Түнх өртөө, БХЯ-ны “Багабаян” амралтын газарт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг гэр бүлтэй нь видео дуудлага хийж видео мэндчилгээ бэлтгэн олон нийтэд хүргэлээ.

Баянзүрх дүүргийн замын цагдаагийн хэлтэстэй хамтран бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын үед үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын урам зоригийг сэргээх зорилгоор “Талархлын захидал” бичиж, халуун чацарганы хамт тараав.

2020 оны 11 дүгээр сарын 16-наас 12 дугаар сарын 11-нийг хүртэлх хугацаанд Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын 2 дугаар хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрийн 22-25 чиглэлд үүрэг гүйцэтгэж буй чуулгын болон тэдэнтэй хамт үүрэг гүйцэтгэж буй давхардсан тоогоор 1940 алба хаагч, ДХИС-ийн сонсогч нарт нийт 19 удаа халуун аньс, чацаргана, аарц, витагрипп, жигнэмэгийг хүргэж өгч ажиллалаа. Мөн чуулгын 70 алба хаагч, ажилтанд 10-12 өдөр уух D, C витамин, хүн тус бүрт 10 ширхэг амны хаалт тарааж дархлааг дэмжих ажлыг зохион байгуулсан байна.

Чуулгын алба хаагчид тэдний гэр бүлийн дунд зохион байгуулсан соён гэгээрүүлэх ажлын хүрээнд: Дэлхий нийтэд “Covid-19” цар тахал гарсантай холбоотойгоор чуулгын 50 алба хаагчийн гэр бүлд захидал хүргүүлэв.

Тус чуулгаас уран бүтээлчдийн мэргэжлийн мэдлэг, уран чадварыг сайжруулах, ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх зорилгын хүрээнд ахмад, дунд, залуу үеийн төлөөлөл болсон Монголын нэрт найруулагч МУСТА Т.Мушка гуайг урьж чуулгын 48 алба хаагч, ажилтан уулзалт-өдөрлөг зохион явуулав.

Олон улсын ахмадын өдөр”-өөр чуулгын ахмадуудад хүндэтгэл үзүүлж баярын тоглолтоо толилуулж, арга хэмжээний үеэр шинээр томилогдсон чуулгын дарга ахмад ажилтнуудтай танилцаж, 2020 оны А/22 дугаартай “Ахмадын зөвлөлийн даргыг томилох тухай” тушаалыг танилцууллаа.

Ахмадын зөвлөлийн даргаар МУГЖ, академич Б.Цэвэлмааг томилж, ахмад ажилтнуудад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх үүрэг чиглэлийг өгсөн болно.

Чуулгын даргын 2020 онб А/20 дугаартай тушаалаар хөгжим ангийн өрөөг МУАЖ, МУУГЗ, нэрт удирдаач, хөгжмийн зохиолч П.Хаянхярваа агсаны нэрэмжит, бүжгийн танхимыг МУГЖ, Д.Ламжавын нэрэмжит, дуу ангийн өрөөг МУСТА С.Галсанцэдэнгийн нэрэмжит, уран сайхны удирдагчийн өрөөг “Чингис хаан одон”-т, МУГЖ, дуучин Г.Ариунбаатарын нэрэмжит өрөө болгож нэр бүхий алдартнуудын ажил, амьдралын түүхэн замнал, алдар гавъяаг хойч үедээ таниулан, алдаршуулах ажлыг зохион байгууллаа.

Тус чуулгаас 2017-2020 онд шинээр хийж туурвисан уран бүтээлүүдээсээ бүрдсэн “Цэрэг ёсоор үүрэг биелүүлснийг илтгэе” уран бүтээлийн тоглолтоо зохион байгууллаа. Тоглолтыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яам, Цагдаагийн ерөнхий газар, хамтран ажиллагч соёл, урлагийн байгууллагуудын төлөөлөл, урлаг соёлын алдартнууд урилгаар үзсэн.

Мөн Соёл урлагийн их сургууль, Монгол Улсын консерватори болон Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн удирдлагууд, багш нар, зочид хүрэлцэн ирж үзэж, уран бүтээлч шавь нартаа үнэлгээ дүгнэлт өгч гурван үеийн уулзалтыг зохион байгууллаа.

2020 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаа, нөхцөл байдалтай танилцах, удирдлага, алба хаагчидтай хийх цахим уулзалтад чуулгын нийт 35 алба хаагч UB Palace-д, 20 алба хаагч ЦЕГ-ын газрын гадна талбайд угтах ажиллагаанд оролцсон.

МУ-ын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийг Цагдаагийн байгууллагад айлчлах үед танилцуулах 18.10 минутын видео кино, 40 нүүр бүхий сэтгүүлийг бэлтгэж ЦЕГ-ын удирдлагад танилцуулсан.

ЦЕГ-ын МДШШУА-аас "Өнгө нэмэгцгээе-2020" нөлөөллийн аяны хүрээнд зохион байгуулж буй "Хариуцлагатай алба хаагч" арга хэмжээний дагуу чуулгын алба хаагчид Монгол цэргийн музейтэй танилцлаа.

Монгол нутаг дахь анхны төрт улс Хүннү гүрнээс орчин цагийн Монгол Улс Энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа хүртэлх Монгол цэрэг, дайчдын бахархалт түүх, эдлэл хэрэглэл, үзмэрүүдийг тайлбартайгаар бие бүрэлдэхүүн үзэж сонирхлоо.

"Өнгө нэмэгцгээе-2020" аяны хүрээнд Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж буй "Хорт зуршил-Эрүүл бие" сэдэвт арга хэмжээний хүрээнд 58 алба хаагчаас Никотины буюу тамхины хамаарлыг илрүүлэх сорил, Архины хамааралтай эсэхийг оношлох Мичиганы сорилоор судалгаа авч дүнг нэгтгэн "Сэтгэлийн цар" сар тутмын сэтгүүлийн "Архины хамаарлын хараат байдлыг арилгах итгэлийг өөртөө бий болгоорой" сэдэвт зөвлөмжийг алба хаагч нарт танилцуулав.

"Хариуцлагатай алба хаагч" арга хэмжээний хүрээнд цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтын зорилго, зорилтыг бүрэн хангах, ажлын цагийн үр ашигтай зарцуулалт ба алдагдлыг илрүүлэх, ажлын ачааллыг бодитой тодорхойлох зорилгоор зохион байгуулсан "Дуран" арга хэмжээг зохион байгуулав.

Чуулгын даргын 2020 оны А/03 дугаар тушаалаар биеийн тамир, спорт хамтлагийг, байгуулж, алба хаагчдын дунд биеийн тамир, спортыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ирэв.

Алба хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 7 хоног бүрийн лхагва гарагт биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийж хэвшсэний дагуу 2020 онд нийт 11 удаа "Хүч" спорт хорооны зааланд бие бүрэлдэхүүн биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийж, чуулгын зоорийн давхарт тохижуулсан фитнесээр 10 алба хаагч тогтмол хичээллэж хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж, бие бялдраа хөгжүүллээ.

Бүртгэл хяналтын төвтэй хамтран алба хаагчдын дунд сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн, чуулгын 2020 оны сагсан бөмбөг, гар бөмбөгийн аварга шалгаруулах "Спорт өдөрлөг"-ийг зохион байгуулж, Хүч спорт хорооноос зохион байгуулсан Хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн, Монголын дугуйн холбооноос зохион байгуулсан уралдаан зэрэгт чуулгын баг тамирчид амжилттай оролцлоо.

Алба хаагчдын бие, бялдрыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор чуулгын бүжгийн багш, бүжиг дэглээч, цагдаагийн дэслэгч Ё.Дамчаабадгар 7 хоногийн 3 өдөр бүжгийн хичээл, дасгал хөдөлгөөн сэдвээр давхардсан тоогоор 980 алба хаагчид нийт 19 удаагийн 38 цагийн сургалт явуулсан. Мөн "Trin-X bike" унадаг дугуйн дэлгүүртэй хамтран хямдралтай үнээр 6 сарын хугацаатай унадаг дугуйн лизингийн худалдааг зохион байгуулж 350.000-850.000 төгрөгийн үнэтэй 7 төрлийн дугуйнаас сонголт хийн 15 алба хаагч, ажилтан худалдан авч дугуйн спортоор сонирхон хичээллэж байна.

2020 оны 08 дугаар сард Монголын дугуйн холбоо, Шүүгчдийн зөвлөлөөс хамтран зохион явуулсан "Эрүүл агаар - эко орчин - эрүүл мэнд" уулын дугуйчдын нэгдсэн аялал ба сорилт бэлтгэлийн "Сонирхогчийн төрөл"-д Цагдаагийн "Сүлд" чуулгын аж ахуйн офицер,

цагдаагийн ахмад Б.Түвшинбаяр ахлагчтай Зэвсэгт хүчний 017-р ангийн тамирчид хамтарсан "Сүлд" баг амжилттай оролцож, XII байранд шалгарав.

Тус чуулгад шинээр томилогдон ахлагчийн бүрэлдэхүүнд орсон 14 алба хаагч цагдаагийн тангараг өргөв.

"Монгол цэргийн өдөр"-т зориулж эмэгтэй алба хаагч, ажилтнуудад эрэгтэй алба хаагчдаас, эрэгтэй алба хаагч, ажилтнуудад эмэгтэй алба хаагчдаас зориулан зохиомжит 2 удаагийн урлагийн тоглолтыг өөрийн тайзнаа толилуулж, хүндэтгэл үзүүлэв.

Мэдээлэл сурталчилгааны ажлын хүрээнд чуулгын үйл ажиллагааг тасралтгүй сурталчлах, мэдээлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг чуулгын даргын 2020 оны А/02 дугаартай тушаалаар баталж, үйл ажиллагааг тухай бүр вэб сайт, фэйсбүүк хуудсанд байршуулж ирэв.

Цагдаагийн байгууллагын 99 жилийн ойд зориулан Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн 600-н студид бэлтгэсэн баярын дугаарт Сүлд чуулгын уран бүтээлчид бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож Хөгжмийн хэсэг МУСТА О.Эрдэнэцогийн "Цагаан шонхорын тэмүүлэл" марш, бүжгийн хэсэг Л.Ламжавын дэглэлт "Цагдаа залуус" бүжиг болон "Жаргалтайн дэлгэр Монгол" дууны бүжиг, дуучид "Үргэлж тантай хамтдаа" "Дуу минь чи нисээрэй", "Жаргалтайн дэлгэр Монгол" зэрэг уран бүтээлүүдээр оролцож 07 дугаар сарын 19-ний өдөр орон даяар цацагдсан.

Үндэсний их баяр наадам, Цагдаагийн байгууллагын 99 жилийн ойг угтаж "Монгол онгод" хамтлагийн тоглолтын бичлэг, "Монгол минь амгалан байна", "Жаргалтайн дэлгэр Монгол" дуунуудын дүрсийг Талын Монгол, ТВ5, Эх орон, ТМ, Royal, С1, ЭКО зэрэг телевизүүдээр олон нийтэд түгээж ажилласан.

Цахим хуудсанд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааны цаг үеийн мэдээлэлтэй холбоотой 23 бичлэг, 27 мэдээ мэдээллийг тус тус байршуулан сурталчилсан байна. Энэ онд 5 телевизийн нэвтрүүлэгт 22 уран бүтээлчид оролцсон нь MNB world сувгийн New generation нэвтрүүлэгт 1, 25 дугаар телевизийн "Урт цагааны гудамж" нэвтрүүлэгт 2, UBS TV "Кофе юу цай юу" нэвтрүүлэгт 2, Өлзий ТВ-ийн "Энх өглөө" нэвтрүүлэгт 12, Монгол HD телевизийн "Өглөө" хөтөлбөрт 5 алба хаагч байв.

Телевизтэй хамтран хийсэн тоглолт, телеконцертын тухайд, сар шинийн баярыг угтан "Монгол түмний сондор аялгуу" ардын дуун эгшиглэнг Эко телевизтэй хамтран бүтээж 10 гаруй телевизээр, Великая победа, Монгол минь амгалан байна, Роял арт, Монгол онгод хамтлагийн лайв тоглолтыг ТВ5, Талын Монгол телевизүүдээр бичүүлж юнивишн, дэдиш, лүүк телевизээр цацсан.

"Үнэнч анд", "Ноёд Хатад", "Талын салхи" бүжиг, "Бүжигчид сайн сайхныг дагуулна", "Дэлхийг тойрсон биелгээ" шторк, Аугаа их эх орны дайны ялалтын 75 жилийн ойд зориулж, 9 орос дууны дүрсжүүлэлт, шинээр "Сүлд подкаст" 2 дугаар, "Сүлд гарагийн зочин" влог 1 дугаарыг бэлтгэж олон нийтийн сүлжээгээр хүргэсэн бөгөөд Хонхот цэцэрлэгт хүрээлэн"-гийн усан оргилуурт "Жаргалтайн дэлгэр Монгол", "Үргэлж тантай хамтдаа", "Улаанбаатарын шөнө" дуунуудын явуулах саналыг Нийслэлийн хот тохижилтын газарт 26/268 дугаартай албан бичгээр илгээж, тус газраас зөвшөөрсний дагуу цэцэрлэгт хүрээлэнгийн усан оргилуурт эгшиглүүлэв.

Эх орны дайны ялалтын 75 жилийн ойн цэргийн парад, Үндэсний их баяр наадам, орчин цагийн Цагдаагийн байгууллагын 99 жилийн ой, Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойд зориулсан чуулгын LIVE тоглолтууд, ЦДЦАБ-д зориулсан тоглолт, Халил уран бүтээлийн тоглолтыг чуулгын фэйсбүүк болон ТВ8, НТВ, Талын Монгол, ТВ5, Эко, Эх орон, ТМ, С1, Өлзий, Малчин, Royal ТВ-р цацсан. Like magazine сэтгүүлд чуулгын уран бүтээлчдийг зочноор оролцуулсан.

Тулгар төрийн 2229, Их монгол улсын 814, Ардын хувьсгалын 99 жилийн ойн баяр наадмын онлайн нээлтийн үйл ажиллагаанд Сүлд чуулгын бүжгийн хэсэг, төрийн хүндэтгэлийн концертод Сүлд чуулгын дуучин, Чингис хаан одонт, МУГЖ, Цагдаагийн хошууч Г.Ариунбаатар МУХБ, АЖ, ТШ Н.Жанцанноровийн хөгжим "Орчлонд ижилгүй нутаг" дуугаар, Сүлд чуулгын уран сайхны удирдагч, цагдаагийн ахлах дэслэгч МУСТА

Ц.Амарболд Г.Бирваагийн хөгжим, Л.Нацагдоржийн шүлэг “Дуу минь чи нисээрэй” дуунуудаар тус тус оролцож хэвлэл мэдээллийн бүхий л сувгаар орон даяар нэвтрүүлсэн.

4 уран бүтээлч 3 уран бүтээлээ клипжүүлэн олон нийтэд сурталчилж, чуулгын бүжигчид Монгол HD телевизээс зохион байгуулсан “Voice of Mongolia” шоуны бүжгийн дэглээч болон бүжгийн багаар хамтран ажилласан.

Чуулгын фэйсбүүк хуудсанд Чуулгын танилцуулга түүх болон шинээр 2 цэс нэмсэн. Цахим хуудасны лайкын тоо 14545, нийт дагагч 17136 болж өссөн үзүүлэлттэй байна.

Чуулгын уран бүтээл, уран бүтээлчид, цаг үеийн талаар 360 градус пост 4, зурган мэдээ мэдээлэл 178, соён гэгээрүүлэх чиглэлээр 105 постер, чуулгын уран бүтээлчид болон чуулгын дэргэдэх Royal Arte, Ongod band, Police band-ын 110 уран бүтээлийн клип, дүрс болон чуулгын алба хаагчдын төрсөн өдрийн 13 зураг, 5 видео мэндчилгээ, “Ятгах тусам нягтал”, “Сүүдэр бүү тусга”, “Өнгө нэмье-2020” нөлөөллийн аян, “Хариуцлагатай албан хаагч”, “Яг одоо”, “Цахим орчинд соёл түгээе, Би хариуцлагатай иргэн” зэрэг аяны 47 постер, 9 бичлэг, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын цаг үеийн ажлын талаар 23 бичлэг, 27 мэдээ мэдээллийг чуулгын цахим хуудсанд тус тус байршуулсан. Бусад эх сурвалжаас 36 мэдээ, 20 бичлэг бүхий мэдээллийг чуулгын алба ёсны цахим сүлжээнд байршуулан сурталчилсан.

Цахим хуудсанд байршуулсан нийтлэлүүдээс Чингис хаан одонт, МУГЖ Г.Ариунбаатарын П.И.Чайковскийн олон улсын уралдааны Гала тоглолтод дуулсан бичлэг 751,915, дуучдын “Монгол минь амгалан байна” дуу 137,126, бүжигчин Э.Энхсайханы “Хайртай челленж”-д нэгдсэн бичлэг 114,282 хандалттайгаар тэргүүлж байна.

Чуулгын цахим хуудсанд COVID-19 цар тахлын үед иргэдийнхээ эрүүл, аюулгүй байдлын төлөө ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтнууд, онцгой байдлын алба хаагч, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагч нарт талархал илэрхийлж, МУСГЗ Л.Гаваасүрэнгийн шүлэг, МУСТА Ш.Өлзийбаярын хөгжим “Монгол минь амгалан байна”, МУСГЗ Л.Гаваасүрэнгийн шүлэг, Д.Мөнхбаярын хөгжим “Үргэлж таньтай хамтдаа” дууг дүрсжүүлэн байршуулснаар 80 гаруй мянган хэрэглэгчид хүрч, 614 удаа хуваалцсан байна.

Экологийн цагдаагийн албатай хамтран “Ирлээ, явлаа цэвэр” аяны хүрээнд “Жаргалтайн дэлгэр монгол” дууны аялгуунд бүжгийн дүрс бичлэг хийлгэж олон нийтийн сүлжээгээр сурталчилсан.

Дэлхий нийтэд тархсан цар тахлын үед ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч, онцгой байдлын алба хаагч, эмч нарт талархал илэрхийлж чуулгын 3 уран бүтээлийг талархлын үгийн хамт байршуулж ажиллав.

Чуулгын даргын баталсан төлөвлөгөөний дагуу “Сүлд” подкастын анхны дугаарыг хийж, зочдоор чуулгын дарга, Үлээвэр хөгжимчдийн холбооны дэд ерөнхийлөгч Г.Цэрэнсүх, ЦДБЭЧ-ын Ерөнхий хормейстр, ахмад О.Эрдэнэцог, чуулгын Ерөнхий удирдаач, цагдаагийн дэслэгч С.Төрбат нартай ярилцаж, 2 дахь дугаарыг Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 381 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Нийслэлийн өдөр” подкастыг хийж Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич Ж.Болдбаатар, Түүхийн ухааны доктор Р.Оюунбат, Ардын дуу судлаач, МУСТА, музейн эрхлэгч, сургалт, эрдэм шинжилгээний ахлах ажилтан, цагдаагийн ахмад С.Дуламсүрэн нар оролцов.

Тус чуулгын үйл ажиллагааг Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвөөс сурвалжилж, олон нийтийн сүлжээнд нэвтрүүлгийг байршуулан сурталчиллаа.

Цагдаагийн музейг хөгжүүлэх чиглэлээр 2020 онд Цагдаагийн байгууллагын музейг шинэчлэн тохижуулах, сан хөмрөгийг баяжуулах, цахимжуулах ажлыг эрчимтэй зохион байгуулж, ЦЕГ-ын даргын болон чуулгын даргын баталсан төлөвлөгөө, хөтөлбөр, холбогдох журмыг мөрдөн ажилласны дээр 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/103 дугаартай тушаалаар баталсан ЦЕГ-ын ЗУГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Үзмэрийн санг баяжуулах, эрдэм шинжилгээний тодорхойлолтыг бичих ажлын хүрээнд ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Дотоодын цэргийн тэнхмийн 6 багшаас галт

музейд хадгалагдаж буй 22 галт зэвсгийн зэвсгийн төрөл зүйл, ангилалын, талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө авсан.

“Цагдаагийн байгууллагын музейг шинэчлэн тохижуулах, сан хөмрөгийг баяжуулах, цахимжуулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний 2.1 дэх хэсэгт заасан ажлын хүрээнд “Иргэн, байгууллагаас цагдаагийн байгууллагын музейд шилжүүлсэн хосгүй үнэт, ховор болон соёлын эд зүйлийг хүлээн авсан талаарх бүртгэл”, “Музейд эд өлгийн зүйл хүлээн авсан, акт, гэрээ”, иргэнд олгох “Талархлын гэрчилгээ”-ний загварын төслийг боловсруулж, 26/233 дугаартай албан бичгээр ЦЕГ-ын ЗУГ-ын даргад хүргүүлэв.

Тус музейд бүртгэлтэй нийт 690 үзмэрээс стандарт шаардлагын дагуу 268 эд өлгийн зүйлсийг шинэчлэн бүртгэж, ангилал, төрөлжилтийг хийж, эрдэм шинжилгээний тодорхойлолтыг бичиж, фото зургийн хамт цахим сан бүрдүүлэн хадгалсан.

Цагдаагийн Ерөнхий Газрын дэд даргаас 2020 оны 3/90 дугаартай албан бичгээр ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийн хүрээнд цагдаагийн музейд Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагуудын хэрэглэж байсан 28 ширхэг туг, далбаа, ТЦА-ы Төмөр зам дахь Цагдаагийн газрын ахмад ажилтан, эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн бэлтгэл хошууч Гонгорын Нацаг агсаны 23 /одон тэмдэг бүхий хантааз, малгай/ ширхэг эд зүйл, 2020 оны 5д/6054 дугаартай албан бичгээр Нийслэлийн цагдаагийн удирдах газраас ирүүлсэн 24 нэр төрлийн 53 ширхэг эд зүйл, 2020 оны 15-1/1812 дугаартай албан бичгээр Тээврийн цагдаагийн албанаас ирүүлсэн 27 ширхэг эд зүйл, ЦЕГ-ын Бүртгэл, хяналтын төв нь тус чуулгын байрнаас нүүж шилжихдээ үлдээсэн 197 ширхэг эд зүйл, 2020 оны 13/1229 дугаартай албан бичгээр Хэрэг бүртгэх албанаас ирүүлсэн 10 нэр төрлийн 26 ширхэг эд зүйл, ЦЕГ-ын Сургалтын нэгдсэн төвөөс ирүүлсэн 14 ширхэг эд зүйл, нийт 340 ширхэг эд зүйлийг хүлээн авч бүртгэлжүүлэн авч, музейн сан хөмрөгийг баяжуулсан.

Цагдаагийн бахархалт 100 үзмэрийг багтаасан цахим музей хийх ажлын хүрээнд “Бахархан дууриах үйлтснүүд” 10 гавьяат, ахмад ажилтны зураг, мэдээлэл, танилцуулга, холбогдох эд зүйлсийн хамт цахимжуулан ЦЕГ, чуулгын цахим хуудсанд байршуулж сурталчлав.

ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн 2020 оны 5г/6044 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн хүрээнд Цагдаагийн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй 1916-1987 оны хязгаарт хамаарах кирилл болон үндэсний монгол бичиг бүхий 20 нэр төрлийн 97 хуудас материал болох “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, холбогдох бичиг баримтуудыг хуулбарлан хүргүүлэв.

ЦЕГ-ын Төв Архивын 2020 оны 25/978 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн хүрээнд Архивын Ерөнхий газраас газраас Төрийн архивын удирдах ажилтан, улсын байцаагчдын нэгдсэн зөвлөгөөний үеэр 5 ширхэг эд зүйлсийг үзэсгэлэнд тавив.

Монгол цэргийн нэгдсэн холбооноос зохион байгуулсан “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын бэлтгэл, чөлөөнд байгаа ахмадуудын уран бүтээл” үзэсгэлэн Монгол цэргийн музейд 2020 оны 11 дүгээр сарын 06-наас 08-ны өдрийн хооронд зохион байгуулахад Цагдаагийн музейн үзмэр, эд зүйлсийг дэлгэн үзүүлж 3 өдрийн турш байгууллагаа амжилттай сурталчиллаа.

Энэхүү үзэсгэлэнд Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын түүхийг харуулсан Арван тавны цагдаагийн дээл, малгай, цагдаагийн шинжээчийн цүнх, мөрдөн байцаагчийн бичгийн машин, албаны эрэлч нохойн чихмэл, цагдаагийн ахмад ажилчдын хийсэн 4 түлхүүртэй монгол цоож, хөгжмийн зэмсэг бусад эд зүйлсийг дэлгэн үзүүлж, уран бүтээлээр үйлчилж, 9 телевизэд мэдээлэл өгч ажиллалаа.

Музейн үзмэрүүдийг орчин үеийн чиг хандлага, стандартад нийцүүлэн цахимжуулах, виртуал үзмэр бий болгох зорилгоор төсвийг ЦЕГ-ын СААА-наас баталж музейн интерьер зураг төслийг “Том-архитектор” компани гарган, төндэрт шалгарч, 2 дугаар давхарын 257 м.кв талбайд засварыг эхлүүлж засварын ажил 90%-тай явагдаж байна.

БЗД дэх Ерөнхий боловсролын 97 дугаар сургуулийн 40 сурагч, эцэг, эхийн зөвлөл, багш нар, ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвд шинээр томилогдсон алба хаагчдад болон тэдний гэр бүлийн гишүүд, хүүхдүүд болох 18 нийт 115 хүнд музейгээр үйлчлэв.

Цагдаагийн музейгээс Цагдаагийн байгууллагын түүхт 100 жилийн ойн хүрээнд бүтээх “Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүхэн баримт бичгийн эмхэтгэл”, “Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүх” номын хэлэлцүүлэгт чуулгын дарга, музейн эрхлэгч /сургалт эрдэм шинжилгээний ахлах ажилтан/ нар оролцов.

Монгол цэргийн нэгдсэн холбооноос зохион байгуулсан Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагийн хэвлэл, олон нийттэй харилцах албаны алба хаагчидтай хийсэн уулзалт зөвлөгөөнд Цагдаагийн Музейн эрхлэгч /сургалт эрдэм шинжилгээний ахлах ажилтан/, цагдаагийн ахмад С.Дуламсүрэн оролцлоо.

Уран бүтээлийн чиглэлээр чуулгын уран бүтээлийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэг бүхий “Уран сайхны зөвлөл”-ийг чуулгын даргын 2020 оны А/23 дугаартай тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж 5 удаагийн хурлаар уран бүтээлийн бодлого, чиглэлтэй холбоотой 8 асуудлыг хэлэлцэж, чуулгын даргад санал танилцуулж ажилласан.

Эхний хагас жилд дууны хэсэг 46, бүжгийн хэсэг 29, хөгжмийн хэсэг 72 буюу нийт 147 уран бүтээлийг чуулгын урын санд нийлүүлж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас ирүүлсэн 84 хүсэлтийн дагуу 12820 иргэд, 6176 цагдаагийн алба хаагч, ахмад ажилтанд урлаг соёлоор үйлчилж иргэд, алба хаагчдын талархалыг хүлээв.

Соёлын яамнаас НЗДТГ-тай хамтран “Танай дүүрэгт-Таны дэргэд” уриатай, иргэдэд соёл, урлагийн үйлчилгээг ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах, уран бүтээлчдээр дамжуулан цар тахлаас урьдчилан сэргийлэх уриалгыг иргэдэд хүргүүлэх зорилгоор “Соёлын цаг” хөтөлбөрийг хэрэгжүүлж, тус хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн Налайх, Баянгол, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул, Багануур дүүргийн 2000 орчим иргэдэд чуулгын бие бүрэлдэхүүн 11 удаагийн урлагийн тоглолтоо өргөн барьж, цар тахлаас урьдчилан сэргийлэх уриалгыг хүргэж, цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг сурталчилж ажиллалаа.

Цагдаагийн ерөнхий газрын Сүлд чуулга нь намар цагийн нээлтийн тоглолтоо дан бүжгийн уран бүтээлийн “Халил” тоглолтоор эхлүүлж, 2 удаа өөрийн байранд амжилттай зохион байгуулан 700 иргэд, урлаг соёлын ажилтнууд үзэж сонирхлоо.

ЦЕГ-ын дэд даргын баталсан цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдад зориулан тоглогдох тоглолтын хуваарийн дагуу Тээврийн цагдаагийн алба, Дотоодын цэрэг, Баянзүрх, Баянгол, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газар, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс, Бүртгэл хяналтын төв зэрэг 8 байгууллагын 2085 алба хаагчид, тэдний гэр бүл, ахмад ажилтнуудад зориулан “Жаргалтайн дэлгэр Монгол” тоглолтыг толилуулж, чуулгын цахим хуудсаар сурталчилж, нийслэл хотод нийт 118 удаагийн хэсэгчилсэн болон нэгдсэн тоглолтыг 24000 орчим хүнийг хамруулан хийсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад дууны уран бүтээл 20 нэгжээр буюу 30%-иар буурсан, хөгжмийн уран бүтээл 9 нэгжээр буюу 11%-иар буурсан, бүжгийн уран бүтээл 5 нэгжээр буюу 17%-иар өссөн, зохион байгуулсан бүрэн хэмжээний болон хэсэгчилсэн урлагийн тоглолт 141 нэгжээр буюу 54%-иар буурсан үзүүлэлттэй байгаа нь дэлхий нийтэд дэгдсэн цар тахлын дэгдэлтээс хамаарч улс орны хэмжээнд бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал, хөл хорио тогтоож, олон нийтэд чиглэсэн соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулахыг хориглосонтой холбоотой боловч уран бүтээлчдийн урын санг баяжуулах, урч чадварыг тасралтгүй хөгжүүлэх, чуулгын үйл ажиллагаа, уран бүтээл, уран бүтээлчдийг хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр сурталчлан таниулахад онцгойлон анхаарч ирсэн.

Тус чуулгаас урын сангаа олонд таашаагдаж, сэтгэлд хоногших цоо шинэ шилмэл уран бүтээлүүдээр баяжуулах 2 томоохон ажлыг зохион байгуулсан нь шилдэг “дууны уран бүтээл” болон “цагдаа марш”-ийн хөгжим бүтээх уралдааныг зохион байгуулсан явдал байлаа.

Нэр бүхий яруу найрагч, хөгжмийн зохиолчдын дунд “Дууны шүлгийн уралдаан”, хөгжмийн нэр бүхий зохиолчдын дунд “Дууны шилмэл аялгуу” уралдааныг зохион байгуулж 12 яруу найрагчаас 47 шүлэг ирүүлснээс 15 шүлэгт 12 хөгжмийн зохиолч аялгуу хийж, I байрыг Ч.Алтантүлхүүрийн шүлэг, Б.Бямбабаярын хөгжим “Жаргалтайн дэлгэр Монгол”, II байрыг Ц.Бавуудоржийн шүлэг, Т.Сэр-Одын хөгжим “Сэтгэлийн гэгээ”, III байрыг Ц.Эрдэнэбаатарын шүлэг, Ш.Өлзийбаярын хөгжим “Учрах тавилан”, тусгай байрыг Ч.Алтантүлхүүрийн шүлэг, Д.Цэвээнравдангийн хөгжим “Дутуугүй нутаг”, Е.Чулууны шүлэг, Д.Дорлигийн хөгжим “Аавыгаа баярлуулаарай” зэрэг уран бүтээлүүд шалгарлаа.

Монгол улсад Хууль зүйн алба үүссэн байгуулагдсаны 110, орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэх бэлтгэл ажлын төлөвлөгөөний 3.12-т заасны дагуу “Цагдаа” маршийн хөгжим бүтээх уралдааныг зохион байгуулж дүгнэв.

Тэргүүн байранд ЦДБЭЧ-ын Ерөнхий хормейстр СТА О.Эрдэнэцогийн “Цагаан шонхорын тэмүүлэл” марш, Дэд байранд Хилийн цэргийн 0164-р ангийн удирдаач СТА Д.Отгонтогтоолын “Цагдаагийн тангараг” марш, Гутгаар байранд ахмад уран бүтээлч УГЗ П.Эрдэнэ-Очирын Түмний хүү “Цагдаа” марш тус тус шалгарсан.

Цагдаагийн 16 маршийн хөгжмийн бүтээлийн бичлэгт мастеринг хийж, цагдаагийн байгууллагын 99 жилийн ойд зориулж 3 маршийн видео бичлэгийг чуулгын албан ёсны фэйсбүүк хуудас болон цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын 22 фэйсбүүк группт байршуулсан.

ЦЕГ-ийн Тээврийн цагдаагийн албанд МУСТА Т.Мөнтунгалагийн “Замын цагдаа” марш, НХЖХОНАБХА-нд МУСТА Г.Батдоржийн “Журамт цагдаа” марш, Эрүүгийн цагдаагийн албанд МУСТА А.Алтансүхийн “Эрүүгийн цагдаагийн алдар”, Дотоодын цэргийн штабт АЖ П.Хаянхярваагийн “Дотоодын цэргийн жавхлантай марш”, Мөрдөн байцаах албанд МУСТА Н.Даваасүрэнгийн “Мөрдөгчийн гавъяа” маршийг 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр чуулгын тайзнаа хүлээлгэн өгч, Сүлд чуулга МУСТА Д.Сэлэнгийн “Сүлд” маршийг чуулгын нэрэмжит марш болгосон.

Чуулгын уран бүтээлчид олон улсын 8 тэмцээн, уралдаанд оролцохоор бүртгүүлсэн боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан тодорхойгүй хугацаагаар хойшилсон байна.

Уран бүтээлчид нь өдөр тутамд гүйцэтгэх дасгал, бэлтгэл сургуулилтыг тасралтгүй явуулж, бүжгийн багш, бүжиг дэглээчийн БНСУ-д модерн бүжгийн 5 сарын сургалтаас олж авсан мэдлэг, туршлагаа тайлагнаж, 10 төрлийн сонгодог дасгалыг чуулгын удирдлага үзэж, танилцан үнэлгээ өгч цаашид анхаарч ажиллах асуудлаар үүрэг чиглэл, зөвлөмж өглөө.

Энэ онд нийт 7 уран бүтээлийн тоглолтыг “ДДЭШ ТВ”, “ЮНИВИШН”, “ГРИЙН ФЮЧЕР”/Лүүк Тв/-ээр дамжуулахаар эхний 3 тоглолтын дүрс бичлэгийг ТВ5, Талын Монгол телевизээр бичүүлж, орос уран бүтээлийн “Великая победа”, нийтийн дууны “Монгол минь амгалан байна” тоглолтыг шууд дамжууллаа. “Великая победа” тоглолтыг нийт 308 хэрэглэгч шууд хүлээн авч үзсэн.

Чуулгын их танхимд 15 арга хэмжээ зохион байгуулагдав.

Гурав.Санхүү, бүртгэл, санхүү хангамж, үйлчилгээ, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах талаар

Тус чуулгад 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар улсын төсвөөс 980,8 сая төгрөг, өөрийн орлого 17,8 сая төгрөг нийт 998,6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилт 980,8 сая төгрөг, өөрийн орлогоор 20,8 сая төгрөг төсөвт төвлөрүүлж бүгд 1,001,6 сая төгрөгийн эх үүсвэртэй ажиллалаа.

Чуулгын 2020 онд тогтмол зардалд 22,1 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 20,0 сая төгрөг, нормативт зардалд 5,3 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын материалын зардалд 36,7 сая төгрөг, дотоод албан томилолтын зардалд 200,0 төгрөг,

газрын төлбөрт 753,2 төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 3,2 сая төгрөгийг тус тус зарцуулж төсвийг үр ашигтай, батлагдсан төсвийг өр, авлага үүсгэлгүй ажиллаа.

Монголын үндэсний аудитын газраас Цагдаагийн ерөнхий газар болон түүний харьяа байгууллагуудад санхүүгийн явцын шалгалт хийгдэж 2020 оны 3 дугаар улирал хүртэлх санхүүгийн баримтуудыг хүлээлгэн өгч шалгуулан, өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу хэрэгжилтийг хангаж, чуулгын даргын тушаалаар хагас, бүтэн жилийн эд хөрөнгийн тооллого хийж хөрөнгүүдийг хаягжуулав.

Мөн ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албаны даргын 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн "Үндсэн хөрөнгө орлогод авах тухай" А/115 дугаар тушаалын дагуу 2,000,000 төгрөгийн үнэ бүхий микшер /Опух1640/ 1 ширхэг, 1,590,600 төгрөгийн үнэ бүхий Зөөврийн компьютер 1 ширхэг, 1,483,333.50 төгрөгийн үнэ бүхий Суурин компьютер 2 ширхэг, 6,940,000 төгрөгийн үнэ бүхий камер SONY 1 ширхэг, 1,480,000 төгрөгийн үнэ бүхий камерийн тогтворжуулагч 1 ширхэг зэрэг хөрөнгийг данс бүртгэл, орлогод авсан.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлагаас "Дууны шилмэл уран бүтээл"-ийн уралдааны 4.400.000 төгрөг, "Цагдаа" марш бүтээх уралдааны 3.960.000 төгрөг, "Жаргалтайн дэлгэр Монгол" дууны фонограмм хийхэд 2.000.000 төгрөг, шууд тололтын тайз 2.160.000 төгрөг, дуу бичлэгийн 16 замтай дижитал фульт, дээврийн засвар зэрэг чуулгын үйл ажиллагаанд материаллаг, болон мөнгөн дэмжлэг үзүүлж ирсэн нь уран бүтээлийн урын сан баяжих, уран бүтээлчдийн ур чадварыг ахихад ихээхэн нөлөөлсөн юм.

Энэ онд уран бүтээлчид хувиасаа 13,1 сая төгрөгийг бүжгийн уран бүтээлд, 31,0 сая төгрөгийг дууны уран бүтээлд, 7,6 сая төгрөгийг хөгжмийн уран бүтээлд, нийт 51,8 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд цаашид тус чуулгыг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын оюуны эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн уран бүтээлийн урын санг баяжуулахад жилийн төсөвт "Уран бүтээлийн төсөв"-ийг тусгуулах шаардлагатай байна.

Монгол улсад хууль зүйн алба үүсэн байгуулагдсаны 110, орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний урлаг, соёлын ажил, арга хэмжээний хүрээнд тус чуулгын хариуцан хэрэгжүүлэх 10 ажлын 229,6 сая, чуулгын концертын их танхимын засварт 365 сая, чуулгын засвар тохижилтод 339 сая төгрөгийн төсвийг шийдвэрлүүлж 2021 онд ихээхэн бүтээн байгуулалт хийхээр ажиллаж байна.

Covid-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажил: Чуулгаас КОВИД-19 цар тахалтай холбоотой 57 постер зөвлөмж, уриалга бэлтгэж, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт үүрэг гүйцэтгэж байгаа Цагдаа, дотоодын цэрэг, ДХИС, Онцгой, Эмч, Мэргэжлийн хяналтын алба хаагч нарт сэтгэлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор чуулгын уран бүтээлээс үүрэг гүйцэтгэж байгаа үеийн зурагт эвлүүлэг бүхий 11 бичлэг, Эрүүл мэндийн яамнаас гаргасан КОВИД-19 нөхцөл байдлын 95 постер мэдээ, 13 зөвлөмж бичлэг, 10 зөвлөмж постер, КОВИД-19 цар тахалтай холбоотой ЗГ, ХЗДХЯ, ЦЕГ, НЦУГ, ХМТ, УСХ, ЭЦА, ТЦА, СНТ, ДХИС-иас бэлтгэсэн 58 постер зөвлөмж, нөхцөл байдлын мэдээ 13, 102 дугаарт ирсэн нөхцөл байдлын 14 мэдээг чуулгын цахим хуудсанд тус тус байршуулсан.

7 хоног бүр чуулгын байранд ариутгалын төхөөрөмжөөр ариутгал хийж, тус чуулгаар үйлчлүүлж буй иргэдэд зориулж, үүдэндээ "Амны хаалтгүй иргэдэд үйлчлэхгүй" тухай санамж, зөвлөмжийг байршуулж, нийт алба хаагчдад амны хаалтыг тогтмол хэрэглэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар чиглэлийг тогтмол өгч, "Түүнчлэн маскаа зүүцгээе" I, II аяны хүрээнд алба хаагчдад 3800 ширхэг амны хаалтыг тарааж тогтмол зүүлгэж хэвшүүлэв.

ЦЕГ-ын СААА-аас тараан олгосон гар ариутгагч 33 ширхэг, амны хаалт 100 ширхэг, спирт /ариутгал/ 45 литр, автомак 2 ширхэг, жавелин 2 сав, амны хаалт /нэг удаагийн/ 313 ширхэг, нэг удаагийн бээлий 740 ширхэг, амны хаалт /даавуу/ 150 ширхэг, амны хаалт N95 65 ширхэг, нүүрний хаалт 24 ширхэг, нүдний шил 24 ширхэг, нэг удаагийн малгай 140 ширхэг, нэг удаагийн улавч 75 ширхэг, хамгаалалтын хувцас 65 ширхэг тус тус авч нийт 2.160.417 төгрөгийн зарцуулалт хийж тайланг тухай бүр ЦЕГ-ын СААА-нд хүргүүлсэн болно.

ЦЕГ- аас нийт 97 литр спирт, 22 ширхэг “Зөв” аарцны ундаа, 15 ширхэг “Чацарганы ундаа”, 68 ширхэг үрэл, 1 сав хлорамин, “Санитас” гар ариутгагч 11 ширхэг, 1000 ширхэг амны хаалт, 200 ширхэг резинен бээлий, ариутгалын бодис ариутгалын төхөөрөмж авч, алба хаагчдын дархлааг дэмжих зорилгоор 1760 ширхэг “Зөв” хатаасан аарцыг хүн нэг бүрт 10 ширхэгээр олгов.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдыг Covid-19 илрүүлэх шинжилгээнд хамруулах ажлыг чуулгын байранд 3 өдрийн хугацаанд зохион байгуулж, нийт 1224 алба хаагч шинжилгээ өгсөн.

Чуулгын 56 алба хаагч түргэвчилсэн шинжилгээ, 50 алба хаагч PCR шинжилгээ өгч бүгд “сөрөг” хариуг авсан байна.

Засвар тохижилт: Чуулгын даргаас ажиллах орчноо тохижуулах талаар үүрэг чиглэл өгч, бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж, чуулгын зоорийн давхар болон бусад давхарт байсан хог хаягдлыг цэвэрлэн, алба хаагчид өөрсдийн албан өрөөг тохижуулах үүрэг чиглэлийг өгсөн. Үүний дагуу чуулгын нэгдүгээр давхрын /Бүртгэл хяналтын төвийн үйлчилгээний танхим ажиллаж байсан/ шилэн тасалгаа бүхий өрөөг ханаар тусгаарлан захиргаа, удирдлагын алба хаагчдын өрөөг тохижуулах, чуулгын даргын өрөөг засварлах, чуулгын байрны үүдний хэсэг дэх плитаг шинэчилж, чуулгын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх ажил явагдаж байна.

Чуулгын дээврийн засварын ажлыг “Төмөрт хос бэрс ХХК” хийж гүйцэтгэв.

ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төв нүүсэнтэй холбогдуулж байгууллагын дотоод сүлжээ, хяналтын камерын холболтуудыг шинэчлэн татаж, эвдрэл гэмтлийг тухай бүрт нь дотоод нөөц бололцоогоо ашиглан засварлаж хэвийн ажиллагаанд оруулж ирэв.

Их танхим, тайз, зоорийн давхар дахь ил цахилгааны утаснуудыг далдлан, 1 давхрын шилэн өрөөнүүдийн цахилгааны самбарыг шинэчлэн сольж, дотор болон гадна талын шатсан гэрэлтүүлгийг сольж, шинэчлэв.

Дулаан алдагдалтай бүжиг ангийн цонхыг битүү силикондож, алба хаагч, ажилтнуудын өрөөний вакум цонхны резинүүдийг шинээр сольж, баруун, хойд зүүн, урд талын хаалгануудад резинен дулаалга нааж дулаан алдагдалтыг бууруулж, чуулгын цэвэр усны муудсан 30 метр шугамыг PPR шугамаар сольж хэвийн ажиллуулав.

Алба хаагч, ажилтнууд болон тус чуулгаар үйлчлүүлж буй иргэдэд зориулж чуулгын нэгдүгээр давхарт “Кофе-шоп” буюу түргэн хоолны газар байгуулахаар засварын ажлыг 80%-тай хийж гүйцэтгэсэн.

Алба хаагчдын нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх ажил: Чуулгын бүжигчин цагдаагийн дэд ахлагч Б.Гантогтох цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй “Цагдаа-Амгалан” хотхоны орон сууцны төсөлд хамрагдаж, 53м² 2 өрөө орон сууцанд орсон, бүжигчин цагдаагийн ахлагч Э.Жаргалмаа тус хотхоны 2020 оны 12 сард ашиглалтад орох орон сууцны захиалгад хамрагдсан.

Хөгжимчин, цагдаагийн ахлах ахлагч О.Амарсанаагийн хувийн орон сууцыг тохижуулахад 80м² ханын цаас, 3 ширхэг цонх, 3 ширхэг цонхны тавцан, 56м² паркетан шал, 26 ширхэг шалны хүрээ, 1200 ширхэг тоосго, 1 тнн цементээр дэмжлэг үзүүлэв.

Чуулгын алба хаагч, ажилчдад “Жимобайл” ХХК-тай хамтран 9212-той дугаарлалт болон хүүгүй лизингийн худалдааг зохион байгуулж 6 алба хаагч, ажилтан 4.640.000 төгрөгийн гар утас 10 сарын хугацаатай худалдаа зохион байгуулсан.

ЦЕГ-аас нэгдсэн журмаар МИГ даатгалд нийт алба хаагчдыг хамруулсан болно.

Тус чуулгын хөгжмийн найруулагч, цагдаагийн ахлахч Б.Мягмарбүрэнхүү нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178, 181 дүгээр тогтоолын дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеэр буюу 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэр Сансрын колонкийн 4 замын уулзварт замын хөдөлгөөний зохицуулалт хийн албан үүргээ гүйцэтгэж байхдаа унаж, зүүн гараа хугалж

гэмтээсэн тул нөхөн төлбөр гаргуулах талаар Практикал даатгалд 26/440 дугаартай албан бичиг, холбогдох материалыг хавсарган хүргүүлэв.

Тус чуулгын хамт олон Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын Нэгдүгээр хэлтсийн хороо хариуцсан цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ч.Чулуун-Эрдэнийн амьдралд тохиолдсон гэнэтийн үйл явдалд 383.000 төгрөгийн хандивыг өргөж, ХААН банкны 5085446121 дугаартай Ц.Уранцэцэгийн дансанд шилжүүлэв.

Дөрөв. Дотоод хяналт, аюулгүй байдлын хүрээнд

Чуулгын даргын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар тус чуулгын “Дотоод аюулгүй байдлыг хангах” орон тооны бус ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, чуулгын дотоод аюулгүй байдлыг хангах 2020 оны 39 ажил, арга хэмжээ бүхий төлөвлөгөөг хавсралтаар баталж, нэр бүхий 9 алба хаагчид нэгбүрчлэн танилцуулж гарын үсэг зуруулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгууллаа.

ЦЕГ-ын ХШДА-ын хэлтсээс ахлах мэргэжилтэн, цагдаагийн хурандаа Д.Пандиймаа, цагдаагийн дэд хурандаа Д.Хөхөө нар байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах ажлын хэрэгжилтийг шалгаж, зөвлөмж чиглэл өгч ажилласан

Чуулгын бие бүрэлдэхүүнд дотоод аюулгүй байдлыг хангах талаар ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор ЦЕГ-ын хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Ч.Болдыг урьж, “Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах нь” сэдвээр алба хаагчдад сургалт явуулж, 55 алба хаагч хамрагдсан.

Чуулгын дуулаачийн, хөгжмийн, бүжгийн хэсгийн ахлагч нар болон хөгжмийн багш, удирдаач, бүжгийн багш, дэглээч, дуулаачийн багш нар зэрэг нийт 6 алба хаагчид албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргийг хэрэгжүүлэх талаар чуулгын дарга, захиргааны удирдлагын тасгийн даргын зааварчилгаа өгч хэрэгжилтийг хангуулж ирэв.

Алба хаагчдын өдөр тутмын ажлын шуурхай байдлыг хангах, урлагийн тоглолтын үед уран бүтээлч, тайзны ажилтнуудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд хүсэлт гаргаж 10 ширхэг гар станцыг албан хэрэгцээнд авч ашиглаж байна.

2020 онд шинэ жил, сар шинэ, үндэсний их баяр наадам, УИХ, орон нутгийн ээлжит сонгууль, бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын эргүүл, тусгаарлах байрны хамгаалалтад давхардсан тоогоор 324 алба хаагч үүрэг гүйцэтгэн нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд зөрчил дутагдалгүй ажиллалаа.

Тусгаарлан ажиглах байрны гадна талын аюулгүй байдлыг хангах, орох гарах хөдөлгөөнд хяналт тавих хамгаалалтад давхардсан тоогоор 25 алба хаагч 7-21 хоногийн хугацаанд ажиллаж, алба хаагчдад УОК, эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг тухай бүр танилцуулан, тусгаарлалтын ногоон бүсийг байгуулан, ариутгалын бодис, халдвар хамгааллын хувцас, хэрэглэлийн тооцоог СААА-нд хүргүүлэн шийдүүлж, тавьж өгч ажиллав.

Үүрэг гүйцэтгэх хугацаанд нь ЦЕГ-ын даргаас өгсөн үүрэг, чиглэлийг алба хаагчдад нэг бүрчлэн танилцуулж, алба хаагчдаас хувийн болон албаны бэлэн байдлыг хангах талаар зааварчилгаа ажлын чиглэл өгч, зөрчил дутагдалгүй үүрэг гүйцэтгэх баталгааг авсан.

Учирч болзошгүй гамшиг аюулын үед байгууллагын эд хөрөнгө, **баримт** сэлтийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж, гамшиг ослын үед нүүлгэн шилжүүлэх, аврах гарцын схемийг давхар бүрт алба хаагчид болон иргэдэд харагдах газарт байршуулж, холбооны дуудлага, дуудах хуваарь, 68 алба хаагчийн хаягийн бүртгэлд тодотгол хийн, шинэчлэн батлуулсан.

Чуулгын хөдөлмөрийн дотоод журмын 8.12-д ЦБ-ын дотоод албаны дүрмийг хэрэгжүүлэх /ЦБҮАЖ код-101/-ын 101.6.2 дахь заалтыг “Албаны бэлэн байдлыг хангахад алба хаагчдын хүлээх үүрэгт заасныг хангах үүднээс чуулгын алба хаагчид ажлын болон ажлын бус цагаар албаны бэлэн байдлыг хангаж гар утсаа нээлттэй байлгаж, чуулгын

дарга, ахлах, жижүүрээс залгасан тохиолдол бүрт хурдан шуурхай хариу өгөх үүрэг хүлээнэ” гэж өөрчлөн алба хаагч нарт танилцуулж, онцгой анхааруулав.

Алба хаагчдын ээлжийн амралт эхлэхтэй холбоотойгоор ЦЕГ-ын дэд даргын 2020 оны 3/77 тоот албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу чуулгын 50 алба хаагч, ажилтнуудаас баталгаа авч ажилласан.

МДШШУА-ны Мэдээллийн технологи, холбооны төвөөс зохион байгуулсан цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд ашиглагдаж байгаа албаны компьютерын үйлдлийн систем, хэрэглээний программ хангамжийг албан ёсны лицензтэй программаар шинэчлэх ажлын хүрээнд чуулгын 20 компьютерт шинэчлэлт хийгдсэн.

Цагдаагийн төв архиваас өгсөн заавар зөвлөмжийн дагуу 2017-2019 оны Тушаал, Өргөдөл, гомдол, зөвлөлийн хурлын тэмдэглэлийг сканердан цахимжуулж, 2007-2016 оны нийт 432 материалаас түр хадгалах 336, байнга хадгалах 82, 70 жил хадгалах 14 материалыг эмхлэн бүртгэлжүүлэв.

Шилэн дансны тухай хуулийн дагуу сар улирал бүр төсвийн гүйцэтгэл, 5 сая төгрөгнөөс дээш дүн бүхий гүйлгээ, төсвийн хөдөлгөөн бололн бусад мэдээллийг шилэн дансны нэгдсэн системд байршуулж төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүр байгууллагын ил тод байдлын самбарт байршуулан ажиллаж байна.

Тус чуулгад дансаар ашиглах боломжтой 25 ширхэг дуулга, 22 ширхэг бамбай, 25 ширхэг хорт утааны баг, 18 ширхэг төмөр гав, 21 ширхэг резинэн бороохой, 4 ширхэг гар станц байгаа бөгөөд 2 ширхэг төмөр гав, 3 ширхэг резинэн бороохойг ашиглах боломжгүй байгаа бөгөөд чуулгын нярав тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад тогтмол хяналт тавьж, холбогдох журмуудын биелэлтийг ханган ажиллаж байна.

Чуулгын байранд стандартын шаардлага хангасан нийт 22 ширхэг галын хор байдаг бөгөөд сар тутам ажиллагааны хугацааг шалгаж хугацаа дууссан галын хорыг дахин цэнэглүүлж ирэв.

Улаанбаатар цагдаагийн хүрээний офицер, ахлагч бүрэлдэхүүнийг зун, өвлийн дүрэмт хувцсанд шилжүүлэх тухай Улаанбаатар цагдаагийн хүрээний даргын тушаалын дагуу чуулгын алба хаагчдын дүрэмт хувцасны үзлэгийг 2 удаа явуулав.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН “СҮЛД” ЧУУЛГА